МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ ХХК
ОРХОН АЙМАГ ДАХЬ ГАЗАР

БАТЛАВ
ДАРГА ..... Б.ЭРДЭНЭБАТ

# ХОЛБООЖУУЛАЛТЫН ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

**Дугаар: А 22 /11/2023**
**Огноо:** 2023.11.20
**Захиалагч байгууллага:** ЭРДЭНЭТ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЛБА
**Хүсэлт гаргагчийн албан тушаал, нэр**: Дарга Б.Одгэрэл

**1. Байршил :** Оюут баг Багийн нэгдсэн байр
**2. Захиалга өгсөн телефоны тоо:** Шилэн кабель
**2.1 Одоо байгаа худаг сувагчлалын хэмжээ:** 18 худаг, 1421 метр бэлэн сувагчлалаар
**3. Холбоожуулалтын үндсэн нөхцөл**

3.1 2-10-р байрны хойно байрлах М-76 худгаас 12 корын шилэн кабелийг муфтлэн 12-р зүйлд заасан бэлэн байгаа холбооны худгууд, шинээр байгуулах худаг сувагчлалаар дамжуулан татаж баригдах барилга руу оруулж төгсгөлд нь FDF цэнэглэнэ. Тус байранд 2х2 м.кв техникийн өрөө гарган 12U маркийн зогсуур байрлуулна.
3.2 Оюут багт байрлах М-517 худгаас шинээр баригдах барилга руу кабель татахын тулд баригдах барилгын подвал хооронд холбооны PVC (100мм диаметртэй) 1 эгнээ яндан бүхий худаг сувагчлалын суурилуулах зай хэмжээг 120 метрээс хэтрэхгүй булан тохой бүрт худаг байхаар тооцох.
3.3 Авто зам, авто зогсоол хөндлөн гарах хэсэгт 130 мм-н 2-оос доошгүй ган яндан суурилуулахаар төлөвлөх.
3.4 2-13 байрны зүүн талд М-101 худгаас М-95 худаг хооронд автозам хөндлөн гарсан сувагчлал дүүрсэн тул нэмэлтээр сувагчлал хийж кабель татах.
3.5 Шинээр баригдсан техникийн өрөөнд хэрэглэгчийн тоонд харгалзсан Gpon төхөөрөмжийг суурилуулж хэрэглэгч тус бүр рүү UTP кабелийг татаж оруулан кабелийг хаягжуулж төхөөрөмж холбох цахилгааны тоолуур, автомат, разеткийн хамт суурилуулах.
3.6 Холбооны худаг сувагчлалын трассын буюу гадна холбооны зургийг Эрдэнэт хотын барилга хот байгуулалтын ерөнхий төлөвлөлттэй уялдуулж Орхон аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай зөвшилцсөний дагуу заавал хийж гүйцэтгэх, газар доогуур инженерийн сүлжээ бүхий ашиглагч байгууллагуудаар хянуулах шаардлагатай.
3.7 Дээрх ажлуудыг гүйцэтгэхдээ МХС ХХК-ийн газартай тохиролцож, ажлын зураг баталгаажуулж гүйцэтгүүлэх шаардлагатай
3.8 Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос олгосон холбооны кабель шугамын угсралт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх шаардлагатай.
3.9 Шинээр баригдах барилга, барилгын холбоожуулалтын зургийг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэн файлаар /CD/ болон хэвлэмэл байдлаар МХС ХХК-д хүлээлгэн өгөх.

**4. Техникийн онцгой нөхцөл:**
4.1 Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос олгогдсон үндсэн сүлжээ байгуулах бүрэн эрхийнхээ дагуу холбоожуулах техникийн нөхцлийг зөвхөн "МХС" ХХК олгох бөгөөд

техникийн нөхцөлгүйгээр холбооны бүх төрлийн үйлчилгээний зориулалтайгаар оптик болон шилэн кабель татсан тохиолдолд уг барилгыг хүлээн авах техникийн болон улсын комисст хүлээн авахгүй болно.

**5. Нэмэлт нөхцөл:**

5.1 Шинээр хийгдэх кабель, шугамын угсралтын ажлын зураг төсвийг зохиохдоо Монгол улсын стандарт MNS 5276:2003, MNS 5279:2003, MNS 5280:2003, MNS 5277:2003 тоот ерөнхий шаардлагууд болон ДБХ-ийн сайдын 1995 оны 127-р тушаалаар батлагдсан зааврыг баримтлан гүйцэтгэх.

5.2 Шинээр хийх сувагчлалын трасс хийх ажлын зургийг МХС ХХК-ийн аймгийн сүлжээний газар, Хот байгуулалт, барилга захиалагчийн алба болон бусад инженерийн шугам сүлжээний холбогдох албан тушаалтнаар хянуулан зөвшөөрөл авч баталгаажуулсан байх шаардлагатай

**6. Зураг төсөвт зайлшгүй тусгах шаардлагатай онцгой нөхцлүүд:**

6.1 Ажлын зураг хийхдээ авто зам болон явган хүний зам орохооргүй нөхцлийг хангах, явган хүний замд орох нөхцөлд таг хүзүүний түвшин тохируулах ажлуудыг тусгаж өгөх.

6.2 Авто зам болон явган хүний зам талбай сэтлэх тохиолдолд сэргээх ажлыг тусгах.

6.3 Авто зам сэтлэх зөвшөөрлийг авто замын газраас авч баталгаажуулах.

6.4 Хэрэглэгчийн шугамын угсралтын ажил барилгын зураг төсөвт байхгүй хийгдээгүй бол захиалагчид мэдэгдэж төсөв зурагт оруулах.

**7. Угсралтын ажлын үед тавигдах нөхцөл:**

7.1 Угсралтын ажил эхлэхээс өмнө зураг төсөв техникийн нөхцлийн дагуу хийгдсэн эсэхийг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ны Аймгийн сүлжээний газрын Шугам кабель бүртгэл төлөвлөлтийн тасгаар (Утас: 70358285) хянуулан баталгааг авсан байх.

7.2 Газар шорооны ажил гүйцэтгэхдээ харъяалагдах тухайн шугам кабелийн нэгжийн ахлах инженер болон инженерээр шалгуулан далд ажлын акт үйлдэж хүлээн авах ажлын актанд хавсаргах.

7.3 Кабель шугамын угсралтын болон газар шорооны ажлыг эхлэхдээ Аймгийн сүлжээний газрын ерөнхий инженерээс албан ёсны мэдэгдлийг авч тухайн харъяалагдах шугам кабелийн нэгжийн ахлах инженерийн хяналтан дор гүйцэтгэнэ.

7.4 Угсралтын ажлын явцад захиалагч ашиглалтын байгууллагатай хамтарч хяналт тавьж угсралтын технологийн шаардлагыг бүрэн хангуулсан байх.

7.5 Хэрэглэгч холбох нөхцлийг бүрдүүлэхийн тулд барилгын дотор монтажийн угсралтыг Монгол улсын стандарт MNS 5471:2005 ерөнхий шаардлагын дагуу хийгдсэн тохиолдолд гадна холбооны угсралтын ажлыг хүлээж авна.

7.6 Мэдээлэл холбооны сүлжээ ХХК -ийн Орхон аймгийн газартай худаг сувагчлалын түрээсийн гэрээг байгуулсаны дараа кабель суурилуулах ажлыг гүйцэтгэх.

7.7 Кабель татагдахад худаг тус бүрт кабелийн биркжүүлэлтийг зүүж, хаяг чиглэлийг тодорхой бичих.

7.8 Монгол Улсын барилгын тухай болон Харилцаа холбооны тухай хуулийн дагуу холбоожуулалтын материалын болон кабель угсралтын ажлын зардал хөрөнгийг барилгын захиалагч хариуцах

**8. Захиалагчид ашиглалтын үед тавигдах шаардлага:**

8.1. Уг сувагчлалын трассыг цааш нь үргэлжлүүлэх болон шинээр кабель татах боломжийг хангах.

8.2. Худаг сувагчлалд техникийн ашиглалтыг хоногийн ямар ч үед ажил үйлчилгээг шуурхай гүйцэтгэх боломжоор бүрэн хангах.

**9. Техникийн нөхцлийг:** ЭРДЭНЭТ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЛБА-ны даргын 2023 оны 11-р сарын 08-ний өдрийн №269 албан тоот бичгийг үндэслэн олгов.

10. Угсралтын ажил дууссаны дараа хэмжилт шалгалт хийлгэж тогтоосон журмын дагуу аймгийн сүлжээний газарт техникийн актаар хүлээлгэн өгсний дараа сүлжээнд холбох зөвшөөрлийг авна.

11. **ЭНЭХҮҮ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ НЬ ОЛГОСОН ӨДРӨӨС ХОЙШ 1 ЖИЛИЙН ХУГАЦААНД ХҮЧИНТЭЙ.**

12. **Бэлэн байгаа худаг сувагчлалын хайгуул**

| Эхлэх цэг | Төгсөх цэг | Урт /метр /кабелийн/ | Яндагийн дугаар | Эхлэх цэгийн байршил |
|---|---|---|---|---|
| М-76 худаг | М1-3-1 худаг | 175 | 3 | 2-10 байрны хойно |
| М1-3-1 худаг | М1-3-2 худаг | 180 | 3 | Сэлэнгийн баруун талд |
| М1-3-2 худаг | М1-3-3 худаг | 140 | 3 | 2-6 байрны баруун талд |
| М1-3-3 худаг | М-109 худаг | 59 | 1 | 2-2 байрны баруун талд |
| М-109 худаг | М-107 худаг | 98 | 1 | 2-2-р байрны зүүн хойно |
| М-107 худаг | М-106 худаг | 20 | 1 | 8-р сургуулийн урд |
| М-106 худаг | М-104 худаг | 70 | 1 | 2-13-р байрны урд |
| М-104 худаг | М-100 худаг | 93 | 1 | 2-13-р байрны зүүн урд |
| М-100 худаг | М-101 худаг | 13 | 1 | 2-13-р байрны зүүн талд |
| М-101 худаг | М-95 худаг | 18 | 1 | 2-13-р байрны зүүн талд /Сувагчлалын багтаамж дүүрсэн. Нэмэлт сувагчлал хийх/ |
| М-95 худаг | М-96 худаг | 110 | 1 | Сайхан төвийн баруун талд |
| М-96 худаг | М-97 худаг | 116 | 1 | Ачит төвийн хойно |
| М-97 худаг | М-97-1 худаг | 18 | 1 | Ачит төвийн хойно |
| М-97-1 худаг | М-99 худаг | 41 | 1 | МСҮТ-н баруун талд |
| М-99 худаг | М-515 худаг | 55 | 1 | МСҮТ-н баруун урд |
| М-515 худаг | М-516 худаг | 95 | 1 | МСҮТ-н урд талд |
| М-516 худаг | М-517 худаг | 120 | 1 | МСҮТ-н урд талд |
| М-517 худаг | | | | МСҮТ-н зүүн урд хашааны гадна талд |
| **Бэлэн сувагчлалаар** | | **1421** | | **М-517 худгаас баригдах барилга хүртэл шинээр сувагчлал хийх, зургийн шатанд худгийн тоо, сувгийн уртын хэмжээ, трасс тогтоох** |

Техникийн нөхцөл олгох комиссын дарга Ц.ЗОРИГ

Гишүүд: Кабелийн инженер Б.САНЖААДОРЖ

ХТБТехникч Б.БАТСАЙХАН

Зөвшилцсөн: МЦХ ХК-ийн ерөнхий инженер: Б.НАРАНЧУЛУУН

2-10-р байр
Бэлэн сувагчлал 1010м
Нийт 1260м
Багийн нэгдсэн байр
DISTRICT 2 2-Р ХОРООЛОЛ
Image © 202
Шинээр хийх сувагчлал
250т